

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ
10 САРЫН БАЙДЛААРХ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр сарын 01

Бүтэц	№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Төлөвлөсөн онд хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
						2024		
Үндсэн чиг үүргийн нэр: 6 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих								
Зорилт	1	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	УТХО 1207,4, Хандив 370,5, ОНХС 130,8	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	86,0	86,7	Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 34 нэр төрлийн 680,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 92.1 хувьтай байна.	100
Арга хэмжээ	1	Сумдын эрүүл мэндийн төвүүдийг мобайл технологиор хангах	УТХО 15.2 Хандив тусламж 77,0	Хангагдсан сумдын тоо	13	15	Эрдэнэдалай, Гурвансайхан, Хулд, Луус, Дэлгэрцогт, Дэрэн сумдын эрүүл мэндийн төвүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мобайль технологи, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлийн санхүүжилтээр мобайль технологитой боллоо. Ингэснээр мобайль технологийн үзлэг оношилгоог 3879 иргэнд хийж, 120 иргэнийг анхан шатны эрүүл мэндийн хяналтад авч, 70 иргэнийг эмчилж эрүүлжүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт 12 иргэнийг шилжүүллээ. Ингэснээр өссөн дүнгээр 15 сумын эрүүл мэндийн төвийн мобайль технологиор хангагдлаа.	100
	2	Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг оношилогоо, эмчилгээний дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах	УТХО 168.1 Хандив 239.9 ОНХС 130,8	Тоног төхөөрөмжийн хангалт Хувь	85.0	86.7	Аймгийн нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт, Зүрх судасны төслийн хүрээнд 137.6 сая төгрөгийн V7N маркын зүрхний ЭХО	100

						<p>аппарат, 30.5 сая төгрөгий өртөгтэй ходоодны уян дуран, НҮБ-ын Хүүхдийн амын сангийн 239.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар STERIPLUS-40 маркийн хог хаягдылн автоклавыг тус тус нийллүүлээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Зооноз өвчин судлалын төвийн лабораторийн чадавхийг сайжруулах зорилгоор PCR -ын шинжилгээний аппарат, дагдалдах хэрэгслэл, био аюулгүй кабинет, лабораторийн ширээ, хөргөгч, хөлдөөгч зэрэг нийт 8 төрлийн тоног төхөөрөмжийг олголоо. Ингэснээр аймгийн Нэгдсэн эмнэлгээс гадна орон нутагт шаардлагатай PCR-ийн шинжилгээг нэмэлтээр хийдэг болсон. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Өлзийт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад нийт 13,0 сая төгрөгийн бүлээцүүлэх хөнжил, 7,8 сая төгрөгийн хэм хяналтын термостат, аймгийн хэмжээний нийт 68 багийн эмч нарын ажиллах нөхцлийг сайжруулах хүрээнд 53.6 сая төгрөгийн багийн эмчийн үзлэгийн цүнхийг тус тус хандивлан өглөө. Орон нутгийн хөгжлийн сангийн 130,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж” нийлүүлэх гэрээний дагуу Мехатроник ХХК-тай байгуулсан гэрээгээр Эхо аппарат /зөөврийн/, 12 сувагтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, биохимийн хагас автомат анализатор, гематологийн анализатор аппарат, хяналтын монитор, дефибрилятор зэрэг 15 нэр төрлийн, 24 ширхэг тоног төхөөрөмжийг сумдын</p>	
--	--	--	--	--	--	---	--

							эрүүл мэндийн төвүүдэд олголоо. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 92.1 хувьтай байна.	
	3	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн автомашины парк шинэчлэлт, багийн эмч нарын унааг үе шаттай хийж, түргэн тусламжийн автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглох	УТХО 927,0	Автомашины хангалт хувь	94,0	95,0	Улсын төсвийн 270,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт, Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвд ЛАНД 76 маркын автомашин, 538,9 сая төгрөгөөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт MANTGE-3180 маркын автомашин, 70,0 сая төгрөгөөр Өндөршил сумын эрүүл мэндийн төвд HIACE маркын автомашин, 23,8 сая төгрөгөөр Сайнцагаан сумын эрүүл мэндийн төвд Прусс маркын автомашин, 23.9 сая төгрөгөөр Говьугтаал сумын эрүүл мэндийн төвд Filter маркийн автомашиныг тус тус хүлээлгэн өгч, яаралтай түргэн тусламжийн бэлэн байдлыг хангалаа. Автомашин хангалт 98.0 хувьтай байна.	100
		УТХО 49,4	Тоногловсон автомашины тоо	4	5	Улсын төсвийн 49,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт, Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвд ЛАНД 76 маркын автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт MANTGE-3180 маркын автомашиныг тус тус иж бүрэн тоногловсон. 3 автомашиныг тоноглож, өссөн дүнгээр 7 боллоо.		
		УТХО 47,7, Хандив тусламж 53,6	Багийн эмчийн унааны тоо	1	2	Багийн эмчийг унаагаар хангах зорилгоор Говьугтаал, Сайнцагаан сумдын эрүүл мэндийн төвийн 2 багт улсын төсвийн 47,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Filter, Прусс маркын автомашинаар хангасан. Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас аймгийн хэмжээний нийт 68 багийн эмч нарын ажиллах нөхцлийг сайжруулах хүрээнд 53.6 сая төгрөгийн багийн эмчийн үзлэгийн цүнхээр хангалаа.		
Зорилт	2	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын	Чанарын үзүүлэлтийн Хувь	47.0	85.0	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 81.2, эдийн засаг	100	

		үзүүлэлтийг 2020 онд 83.0 байсныг 2024 онд 85.0 хүргэнэ.					нийгмийн үзүүлэлт 91,7% ба дундаж хэрэгжилт 96,4 хувьтай байна.	
Арга хэмжээ	1	Явуулын тусламж, үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	УТХО 7,8	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь	33,8	34,0	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч зудын гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 5 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг томилгоожуулан 14 сумдад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж нийт 2096 иргэн, Улсын Нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтарсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог аймгийн хэмжээнд 6 суманд төвлөрүүлэн 15 хоногийн хугацаанд 18 дээш насны 1083 иргэнийг тус тус хамрууллаа. Нийт 3179 иргэн үзлэгт хамрагдлаа. Эхний 10 сарын байдлаар амбулаторийн тусламж үйлчилгээний 148974 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс 30643 иргэн хамрагдаж 20,6 хувьтай байна. Нийт өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилт 30,0 хувь	50
	2	Хот хоорондын зам дагуу болон алслагдсан сумдад яаралтай тусламжийн цэг байгуулах	ОНХС 56,2	Цэг байгуулсан сумдын тоо	4	5	Сайнцагаан сумаар дамжин өнгөрөх Автозамын пост, Хулд, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвийг түшиглэсэн яаралтай тусламжийн цэгийг байгууллаа. Тус цэгүүдээр 45 зам тээврийн осол, 8 бусдад зодуулсан, 16 уналт, таталт, 15 хурц иртэй зүйлд зүсэгдсэн, 1 осголт, 6 түлэгдэлт, 25 хордлого, 7 амьтанд хазуулсан зэрэгт анхан шатны тусламж үйлчилгээ үзүүллээ. Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө. Ингэснээр 5 сумын эрүүл мэндийн	100

							төвүүдийг түшиглэн яаралтай тусламжийн цэгийг байгуулан яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 79,5 хувьтай болж, нийт 125 хүнд яаралтай тусламжийг 100 хувь үзүүллээ.	
3	Олон улсын эмнэл зүйн UP TO DATE 'програмыг эмч бүр ашиглах,алсын зайн оношлогоо, зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлж эмч нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах	УТХО 32,0	Ашиглалтын хувь	0	100	Олон улсын эмнэл зүйн UP TO DATE цахим платформыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн 100 хувь нь ашиглаж байна. Эхний 10 сарын байдлаар нарийн мэргэжлийн төвөөс зөвлөгөө 7 удаа, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар 9 удаа зөвлөгөөг тус тус өгсөн	100	
			Хангалтын хувь	45	100	Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Хулд, луус, Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвүүд нь нийт 10 компьютерийн хангалт хийж, эрүүл мэндийн салбарын албан хаагч нарын албан хэрэгцээнд зориулан цахимаар эмчилгээ үйлчилгээ, оношилгоо авах боломжийг бүрдүүллээ. Шинээр авсан компьютер 10 өссөн дүнгээр 59 болсон. Хангалт 100 хувь.		
4	Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах	УТХО 16.5	Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлт/Просантим иль	0	0	Эхний 10 сарын байдлаар нийт 467 эх төрж, амьд төрөлт 468 бүртгэгдсэн. Нийт төрсөн эхчүүдийн 96,3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтад төрсөн байна. Жирэмсний эрт үеийн хяналт 97,1 байгаа бөгөөд урьд оны мөн үеэс 6,1 хувиар өссөн байна. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	100	
			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлт/Промиль	10.0	7.0	Эхний 10 сарын байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд болж хувиар буурсан байна.		

Зорилт	3	Халдварт бус өвчлөлийн түвшинг 2020 оны 7441.5 байсныг 2024 онд 7241.5 болгож бууруулна.	ЭМДСан 640.0	10000 хүн амд ногдох халдварт бус өвчлөлийн түвшин Промиль	7441.5	7291.5	Халдварт бус өвчлөлийн түвшин 10000 хүн амд 7282,3 ногдож байгаа бөгөөд хүн амын дунд Зүрх судасны өвчлөл тэргүүлж байна.	100
Арга хэмжээ	1	Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчинг бүрдүүлэх.	УТХО 14,0	Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо	37	46	2024 оны “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, иргэн, өрх гэр бүл”-г шалгаруулах болзол, журмыг Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 3 сарын 5-ны өдрийн 01/128 тоот албан бичгээр нийт байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн. Болзол журмын дагуу шалгаруулалтыг 4 дүгээр улиралд зохион байгуулагдана. 2021 оноос хойш “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”-ний тоо аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 49, Эрүүл мэндийг дэмжигч байгууллага өссөн дүнгээр 41 тус тус болж нийт эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо 90 боллоо.	100
				Хог хаягдлын автоклаваар хангагдсан ЭМБ-ын тоо	0	9	Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд хог хаягдлын автоклаваар 100 хувь хангагдсан.	
	2	Хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийг бууруулах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх .	ЭМДСан 640.0 УТХО 16,2	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын хувь	24.3	33.8	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч зудын гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 5 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг томилгоожуулан 14 сумдад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж нийт 2096 иргэн, Улсын Нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтарсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог аймгийн хэмжээнд 6 суманд төвлөрүүлэн 15 хоногийн хугацаанд 18 дээш насны 1083 иргэнийг тус тус хамрууллаа. Нийт 3179 иргэн үзлэгт хамрагдлаа. Эхний 10 сарын байдлаар амбулаторийн тусламж үйлчилгээний 148974 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс	60

						30643 иргэн хамрагдаж 20,6 хувьтай байна. нийт өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилт 30,0 хувь	
			Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	65	67,4	Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 22395 иргэнээс 13751 буюу 61,4%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 15747 иргэнгээс 12104 буюу 76,9%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2301 иргэн иргэнээс 1442 буюу 62,7%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8043 иргэн хамрагдахаас 4801 буюу 59,7%-тай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 41, чихрийн шижинтэй 4 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авч эмчилгээнд хамрууллаа. Үүний үр дүнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 65,2 хувьтай байна.	
			Эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь	59.4	74.4	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу танхимын сургалтыг 357 удаа 28859 иргэнийг хамруулан 5125 ширхэг гарын авлага материалыг тараан зохион байгуулсан байна. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслээр 512 удаа мэдээлэл, зөвлөмжийг түгээж хандалтаар 213,809 хүн үзэж мэдээлэл авсан байна. Мэдээлэл, сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэд давхардсан тоогоор 45783 буюу 90,0 хувьд хүргэсэн байна.	
3	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах	ДЭМБ 77,8 Хандив 9,3, УТХО 3,5	Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн	58,0	60,0	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл	100

	чадавхийг бүрдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх.		нөөцийн хангалтын хувь			мэндийн байгууллагын нөөц"-д байвал зохих 46 нэр төрлийн эм, 39 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 11 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 6 нэр төрлийн тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн оношлуур, 7 нэр төрлийн ариутгал халдваргүйтгэлийн бодисыг бүрдүүллээ. Хангалт 86,9 хувьтай байна.
			Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	85,0	90,0	2023 оны А/211 тушаалаар батлагдсан 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийн хангалт 90,7 хувьтай байна.
			Дархлаажуулалтын хамралтын хувь	94.4	96.0	Заавал хийх товлोलт дархлаажуулалтад хамралт 95,1 хувьтай байна
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ						95,5

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭЖ ГАРГАСАН:

ЭМГ-ЫН ХШУДА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



П.ОЮУНЧИМЭГ

ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.АЛТАНТӨГС

